



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 07 өдөр

Дугаар 8/419

Есөнбулаг

Г Гэрээ шууд байгуулж, гүйцэтгүүлэх  
эрх шилжүүлэх тухай Т


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг, 46 дугаар зүйлийн 46.1.8 дахь заалт, 46.3 дахь хэсэг, Засгийн газрын 2021 оны "Босго үнэ шинэчлэх тухай" 124 дүгээр тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн "Аймгийн 2023 оны төсвийн тодотгол батлах тухай" 23 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн 1,093,897 (нэг сая ерэн гурван мянга найман зуун ерэн долоо) төгрөгийн хөрөнгө оруулалтаар хийгдэх Үйлдвэрчний эвлэлийн хорооны барилгын гадна фасадны засварын ажлыг шууд гэрээ байгуулж, гүйцэтгүүлэх эрхийг аймгийн Үйлдвэрчний эвлэлийн хороо (Л.Сумаахүү)-нд шилжүүлсүгэй.

2. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулж шаардлага хангасан гүйцэтгэгчтэй гэрээ байгуулан, захиалагчийн хяналт, хариуцлагыг гэрээнд тодорхой тусгаж, хэрэгжилтэд хяналт тавьж, тайлагнаж ажиллахыг аймгийн Үйлдвэрчний эвлэлийн хороо (Л.Сумаахүү)-нд тус тус үүрэг болгосугай.

3. Ажлын гүйцэтгэл, чанар, санхүүжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ), Санхүү, төрийн сангийн хэлтэс (Х.Баатарзориг)-т тус тус даалгасугай.





Digitized by srujanika@gmail.com

ମିଶନାରୀ ପଦ୍ଧତିରେ / ଏ / ଲେଖାକ୍ (ଫ୍ରେଂଚ- ହାତାର୍) । କୋଡ଼ିଟି + ପଦ୍ଧତି ଏ / ଆଜୁ ଏ / ଲେଖାକ୍ (ଫ୍ରେଂଚଭାଷାରେ) ଏହି ଗଣ୍ଯ ଗତି  
ଏ .. ହାତାର୍ ଏ / ମିଶନାରୀ । ହାତାର୍ + କୋଡ଼ିଟିରେ / ଏହି ଲେଖାକ୍ / କୋଡ଼ିଟି ହାତାର୍ରେ ଏହି ଲେଖାକ୍ / ଏହି କୋଡ଼ିଟିରେ / ।  
କୋଡ଼ିଟିରେ ହାତାର୍ରେ ଏହି ଲେଖାକ୍ / ଏ ଏହି ଏ / ଲେଖାକ୍ (ଫ୍ରେଂଚଭାଷି) ଏହି ଗଣ୍ଯ ଗତି ମିଶନାରୀ ..  
ଏହି ମିଶନାରୀ / । ଲାଇଟାର୍ମ ଏ / ଲେଖାକ୍ / । ମିଶନାରୀରେ / ଏ ଏହି କୋଡ଼ିଟି ହାତାର୍ରେ / ଲେଖାକ୍ / ଏହି ଲେଖାକ୍ / କୋଡ଼ିଟି ..  
କୋଡ଼ିଟି ଲାଇଟାର୍ମ ହାତାର୍ରେ ଏ / କୋଡ଼ିଟି ଲିଟାର୍ଗ୍ରେଫ୍ / ଲାଇଟାର୍ମ ହାତାର୍ରେ / ଏହି ଲିଟାର୍ଗ୍ରେଫ୍ / ମିଶନାରୀରେ ଏହି  
ଏ .. ପଦ୍ଧତି ଏ / କୋଡ଼ିଟି / ସଫାର୍ / ପଦ୍ଧତି ଏ / ମିଶନାରୀ ଏହି ଲିଟାର୍ଗ୍ରେଫ୍ / । ହାତାର୍ .. ପଦ୍ଧତିବାନୀରୀ ଲିଟାର୍ଗ୍ରେଫ୍ / ଲାଇଟାର୍ମ  
(ଫ୍ରେଂଚଭାଷି) ଏହି କୋଡ଼ିଟିରେ ..

ମୋ ହେଉଥିଲା କିମ୍ବା କିମ୍ବା କିମ୍ବା । କିମ୍ବା କିମ୍ବା କିମ୍ବା ।